

Translated from Mongolian to Chinese

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн
16 дугаар тогтоолын тавдугаар хавсралт

董事会2025年3月18日第16

号决议的附件5

盖章/盖章蒙古证券交易所/

**ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ
СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例**



**ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ ТОГТООХ,
МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**

铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

Нэг.Ерөнхий үндэслэл/一、一般规定	2
Хоёр.Арилжааны гэрээнд тавигдах шаардлага/二、交易协议的要求	2
Гурав. Арилжааны гэрээг байгуулсанд тооцох, биржид бүртгүүлэх/三、交易协议达成的认定与在交易所注册	3
Дөрөв.Арилжааны гэрээний төлбөр, тооцоо/四、交易协议的支付与结算	4
Тав.Арилжааны гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт/五、交易协议的执行与监督	4
Зургаа.Арилжааны гэрээг дуусгавар болгох, түүний үр дагавар/六、交易协议的终止及其后果	5
Долоо.Тээвэр, хадгалалт, чанарын хяналт/七、运输、仓储及质量监管	6
Тээвэр логистик/运输与物流	6
Агуулахын баримт, хадгалалт/仓库收据与仓储	7
Чанарын хяналт/质量监管	8
Найм.Бусад/八、其他事项	

Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

Dynamic translation center

Tel: 976-95904858

Email: dynamictranslation123@gmail.com



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16 дугаар тогтоолын Тавдугаар хавсралт
董事会2025年3月18日第16号决议的附件5

**ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ
СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例**

Нэг.Ерөнхий үндэслэл

一、一般规定

- 1.1. Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-иар арилжаалсан төмрийн хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.1. 本条例规范通过“蒙古证券交易所”股份公司（以下简称“交易所”）进行交易的铁矿石及精矿交易协议标准的制定及其执行监督相关事宜。
- 1.2. Энэхүү журамд заасан үйл ажиллагаа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ.
- 1.2. 本条例所述活动依据《矿产商品交易所法》、其他相关法律法规、金融监管委员会（以下简称“委员会”）及交易所制定的规章、指引以及依其制定的其他决议执行。
- 1.3. Энэхүү журмыг Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.
- 1.3. 本条例适用于交易所交易参与者及市场其他参与方。

Хоёр.Арилжааны гэрээнд тавигдах шаардлага

二、交易协议应满足的要求

- 2.1. Гэрээгээр арилжаалах төмрийн хүдэр, баяжмалын 1 багц 50 вагон буюу 3,250 тонн (бүтээгдэхүүний төрлөөс хамаарч ± 10 хувь байж болно) байна.
- 2.1. 依照协议进行交易的铁矿石、精矿每1批为50节车厢或3,250吨（可根据产品类型上下浮动 $\pm 10\%$ ）。
- 2.2. Форвард гэрээний хугацаа 6 сар хүртэл хугацаатай байна.
- 2.2. 远期协议的期限为不超过6个月。

Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

- 2.3. Спот гэрээний хугацаа 30 буюу түүнээс доош хоногийн хугацаатай байна.
- 2.3. 现货协议的期限为30日或以下；
- 2.4. Төмрийн хүдэр, баяжмалын чанарын зөрүүнд үндэслэн үнийн нэмэгдэл, бууралтыг тооцож болно.
- 2.4. 可根据铁矿石、精矿的质量差异计算价格的增加或减少。
- 2.5. Энэхүү журмын 2.4-т заасан бүтээгдэхүүний үнийн нэмэгдэл, бууралтыг тооцохоор бол түүний аргачлал, хувь хэмжээг Биржид ирүүлэх арилжааны зард тодорхой тусгаж арилжааны гэрээнд заавал оруулсан байна.
- 2.5. 如根据本条例第2.4条规定对产品价格进行增加或减少，相关计算方法及幅度应在提交至交易所的交易广告中明确列出，并必须在交易协议中予以注明。
- 2.6. Биржид ирүүлэх арилжааны зард үнийн нэмэгдэл, бууралтыг тооцсон аргачлал, хувь хэмжээг тусгаж ирүүлээгүй бол чанарын хэлбэлзэлд тооцох үнийн нэмэгдэл, бууралтгүй гэж үзэн арилжааны гэрээг байгуулна.
- 2.6. 如提交至交易所的交易广告中未包含价格增加或减少的计算方法及幅度，则视为不对质量波动计算价格增加或减少，并据此签订交易协议。
- 2.7. Форвард гэрээний хувьд зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан гэрээний үнийг тохируулж болох бөгөөд үнийн тохируулгын нөхцөл, тооцох аргачлалыг тодорхой тусгана.
- 2.7. 就远期协议而言，可根据市场状况调整协议价格，并应明确约定价格调整的条件和计算方法。
- 2.8. Арилжааны гэрээ болон түүнтэй холбоотой бусад харилцаанд зөвхөн Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.
- 2.8. 交易协议及其相关关系仅适用蒙古国法律。

Гурав. Арилжааны гэрээг байгуулсанд тооцох, биржид бүртгүүлэх

三、交易协议达成的认定与在交易所注册

- 3.1. Уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаа амжилттай зохион байгуулагдаж, хэлцэл хийгдсэнээр арилжааны гэрээ байгуулагдсанд тооцож, Биржид бүртгэгдэнэ.
- 3.1. 当矿产商品电子交易成功进行并达成协议后，即视为交易协议已成立，并在交易所完成注册。
- 3.2. Арилжааны гэрээг байгуулахдаа гэрээний хугацаа эхлэх өдрийг арилжааны системд хэлцэл амжилттай хийгдсэн өдрөөр тусгана.
- 3.2. 在签署交易协议时，应将协议起始日期登记为交易系统中成功达成协议的日期。
- 3.3. Талууд арилжааны гэрээг хэлцэл биелснээс хойш ажлын 5 өдрийн дотор байгуулан Биржид ирүүлэх үүрэгтэй. Гэрээг байгуулж ирүүлээгүй нь гэрээний үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

- 3.3. 双方应在达成协议后的5个工作日内签署交易协议并提交至交易所。未提交签署协议并不构成免除协议责任的理由。
- 3.4. Талууд арилжааны гэрээг байгуулахдаа системд хийгдсэн хэлцлийн дагуу байгуулна.
- 3.4. 双方在签订交易协议时，应依据系统中达成的协议内容进行订立。
- 3.5. Талуудын байгуулсан арилжааны гэрээ болон түүний нэмэлт гэрээг тухай бүр Биржид бүртгүүлнэ.
- 3.5. 双方签署的交易协议及其补充协议应分别在交易所完成注册。

Дөрөв.Арилжааны гэрээний төлбөр, тооцоо

四、交易协议的支付与结算

- 4.1. Спот гэрээний нийт төлбөрийг худалдан авагч нь хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 4.1. 投标者应在协议成交成功后7个工作日内，将现货协议的全部款项汇入卖方账户。
- 4.2. Форвард гэрээний төлбөрийг дэнчин хассан дүнгээр худалдагчаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор шилжүүлнэ.
- 4.2. 远期协议的付款应在成交成功后7个工作日内，依据卖方提供的付款通知，扣除保证金后的余额转入卖方账户。
- 4.3. Арилжааны гэрээний төлбөр, тооцоо гүйцэтгэх бусад харилцааг “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-д заасны дагуу зохицуулна.
- 4.3. 与交易协议款项支付与结算相关的其他事项，依照《矿产商品交易所交易结算条例》的规定执行。

Тав.Арилжааны гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт

五、交易协议的执行与监督

- 5.1. Худалдагч эсхүл түүний брокер нь спот, форвард гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг Биржид сар бүрийн 10-ны өдөр шинэчлэн ирүүлнэ.
- 5.1. 卖方或其经纪人应于每月10日，向交易所更新提交现货及远期协议的履约信息。
- 5.2. Энэхүү журмын 5.1-т заасан тайланд дараах мэдээллийг тусгасан байна.Үүнд:
- 5.2. 本条例的第5.1条所述报告应包含以下信息
- 5.2.1. бүтээгдэхүүний төлбөр төлсөн баримт;

Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

- 5.2.1. 产品付款凭证;
- 5.2.2. нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ;
- 5.2.2. 已供应产品的数量;
- 5.2.3. тээвэрлэлтийн мэдээлэл;
- 5.2.3. 运输相关信息;
- 5.3. Бирж нь арилжааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор худалдагч эсхүл түүний брокероос нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 5.3. 为监督交易协议的履行情况, 交易所可要求卖方或其经纪人补充提交相关信息。
- 5.4. Арилжааны гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, шинжилгээ хийлгэхдээ зөвхөн Биржийн итгэмжлэгдсэн этгээдээр гүйцэтгүүлнэ.
- 5.4. 在履行交易协议过程中, 与产品的仓储、运输和检验等相关活动, 仅可由交易所授权的机构执行。

Зургаа.Арилжааны гэрээг дуусгавар болгох, түүний үр дагавар

六、交易协议的终止及其后果

- 6.1. Арилжааны гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 6.1. 在以下情形下, 交易协议将被终止:
 - 6.1.1. талууд гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор харилцан тохиролцсон;
 - 6.1.1. 双方协商一致同意提前终止协议;
 - 6.1.2. талууд арилжааны гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн;
 - 6.1.2. 双方已完全履行交易协议项下的责任;
 - 6.1.3. холбогдох хууль тогтоомж болон гэрээнд заасны дагуу гэрээ дуусгавар болох үндэслэл бий болсон.
 - 6.1.3. 根据相关法律法规或协议条款出现协议终止的法定事由。
- 6.2. Гэрээг дуусгавар болгоход баримтлах нөхцөл
- 6.2. 协议终止应遵循以下条件:
 - 6.2.1. Худалдагч, худалдан авагч тал нь гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор харилцан тохиролцсон бол гэрээг дуусгавар болж байгаа үндэслэл, шалтгаан болон дэнчинг гэрээний аль талд шилжүүлэх тухай акт үйлдэж, тус актыг Биржид ирүүлнэ.

Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

- 6.2.1. 若卖方与投标者协商一致决定提前终止协议，应就协议终止的依据、原因及保证金 归属等事项签署一份说明文件，并提交至交易所；
- 6.2.2. Талууд арилжааны гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн бол Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-д заасан баримт бичгийг Биржид ирүүлнэ.
- 6.2.2. 若双方已完全履行协议责任，应按交易所《矿产商品交易所交易结算条例》中的规定，提交相关证明文件。
- 6.3. Гэрээг дуусгавар болгосон, хүчингүйд тооцсоны үр дагавар
- 6.3. 协议终止或视为无效所产生的后果：
- 6.3.1. Гэрээг дуусгавар болгосон тохиолдолд арилжааны дэнчинтэй холбоотой харилцааг Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-аар зохицуулна.
- 6.3.1. 若协议已终止，与交易保证金相关的关系应依据《矿产商品交易所交易结算条例》予以处理。
- 6.3.2. Арилжааны системд хийгдсэн арилжааны гэрээг талууд журамд заасан хугацаанд бичгээр байгуулаагүй бол тухайн гэрээг цуцлах, дуусгавар болгохтой холбоотой харилцаанд 6.1, 6.2-т заасан зохицуулалт нэгэн адил хэрэглэгдэнэ.
- 6.3.2. 若双方未在条例规定期限内签订交易系统中已达成的交易协议，则关于该协议的取消或终止相关事宜，应同样适用第6.1条和第6.2条所规定的安排。

Долоо.Тээвэр, хадгалалт, чанарын хяналт

七、运输、仓储及质量监管

Тээвэр логистик

运输与物流

- 7.1. Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх ажиллагааг худалдагчтай гэрээ байгуулсан Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч гүйцэтгэнэ.
- 7.1. 将产品从认证仓库或中转站运送至交付地点的工作，应由与卖方签署协议的经交易所授权的 运输物流服务商负责执行。
- 7.2. Худалдагч нь хүргэлт хийх тээврийн хэрэгслийн дугаар, хүргэлтийн маршрут, бүтээгдэхүүн, тоо хэмжээ, очих хугацааны талаарх мэдээллийг итгэмжлэгдсэн агуулах,

Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

терминалд бүтээгдэхүүнийг хүргэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.

- 7.2. 卖方应在产品交付至授权仓库或中转站的3天前，向相关方通知运输工具编号、运输路线、产品种类、数量及到达时间等信息。
- 7.3. Худалдан авагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Худалдагч нь бүтээгдэхүүний гэрээнд заасан газарт хүргэх хүртэл хугацааны тээвэрлэлтийн эрсдэлийг хариуцна.
- 7.3. 除非与投标者签署的协议中另有约定，卖方应承担产品在运输至协议指定地点期间的运输风险。
- 7.4. Тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсан этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.
- 7.4. 运输物流服务商应对与其签订运输协议的当事方承担责任。
- 7.5. Худалдан авагч Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгчийг ашиглахгүйгээр бүтээгдэхүүнийг хүлээн авах бол ачилт хийгдсэнээр хүргэлтийн үйл ажиллагаа дууссан гэж үзнэ.
- 7.5. 若投标者不使用交易所授权的运输物流服务商自行接收产品，则在装车完成后即视为交付责任已履行完毕。

Агуулахын баримт, хадгалалт

仓库收据与仓储

- 7.6. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, ачилт хийж дуусах хүртэл чанар, тоо хэмжээ, аюулгүй байдлыг хариуцна.
- 7.6. 经授权的仓库或中转站负责在产品接收，至装载完成期间，保障产品的质量、数量与安全。
- 7.7. Итгэмжлэгдсэн агуулах терминал нь бүтээгдэхүүнийг хадгалахдаа үндэсний холбогдох стандартад заасан хадгалалтын нөхцөлийг баримтлахаас гадна дараах нөхцөлийг бүрдүүлж ажиллана:
- 7.7. 经授权的仓库或中转站在储存产品时，除遵守国家相关标准规定的存储条件外，还需满足以下条件：
- 7.7.1. Камерын хяналтын системийг бүрдүүлсэн байх;
 - 7.7.1. 配备视频监控系统;
 - 7.7.2. Бүтээгдэхүүний овоолгын нэршлийн самбартай байх.
 - 7.7.2. 产品堆要有标识牌。
- 7.8. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь Биржээр арилжих, арилжсан бүтээгдэхүүнийг хүлээн авч “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын Хавсралт 3 /цаашид “агуулахын баримт” гэх/-г үйлдэн Биржид ирүүлнэ.
- 7.8. 经授权仓库、中转站应接收通过交易所交易的产品，并依据《矿产商品的交易所参与条例》附件3（以下简称“仓库收据”）制作相关文件并提交至交易所。

Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

- 7.9. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь итгэмжлэгдсэн лабораториор дээж авхуулах, шинжилгээ хийлгэх үйл ажиллагаанд хамтарч ажиллана. Худалдагч эсхүл брокер нь шинжилгээний дүнг Биржид ирүүлнэ.
- 7.9. 经授权的仓库或中转站须配合授权实验室进行采样及检验。卖方或其经纪人负责将检验结果提交至交易所。
- 7.10. Худалдагч нь худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авсан тухай баримтыг Биржид ирүүлснээр Бирж бүтээгдэхүүнийг хүлээн авах мэдэгдлийг худалдан авагч, эсхүл брокер болон итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 7.10. 卖方根据与投标者签署的协议收到货款后，须将付款凭证提交至交易所，由交易所向投标者、经纪人及授权仓库或中转站发出把产品接收的通知。
- 7.11. Худалдагч нь агуулах, терминалаас ачилт хийхээс ажлын 3 хоногийн өмнө энэ талаар итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэж, бүтээгдэхүүнийг хүлээн авах этгээдийн биеийн байцаалт, чингэлэг, тээврийн хэрэгсэл болон бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийн талаар мэдээллийг урьдчилан итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 7.11. 卖方应在拟从仓库或中转站发货前3个工作日通知授权仓库或中转站，并提前对拟从仓库或中转站提供收货人地个人身份信息、集装箱、运输工具及产品接收通知信息。
- 7.12. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүний ачилтыг хийн худалдан авагчид хүлээлгэн өгч акт үйлдэн, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгийн хамт Биржид ирүүлнэ.
- 7.12. 经授权的仓库或中转站应根据协议完成产品装运并交付给投标者，同时出具交付确认书，并附上授权实验室的检验结果，一并提交至交易所。
- 7.13. Спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүнийг арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулж, бүртгэсэн байна.
- 7.13. 现货交易的产品应在交易举办日前至少5个工作日存入并登记在授权仓库或中转站。
- 7.14. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, хүлээлгэн өгөх бүртгэлийг хөтлөх бөгөөд Бирж нь хяналт, шалгалтын зорилгоор бүртгэл, агуулахын баримтыг тухай бүр шалгах үүрэгтэй.
- 7.14. 经授权的仓库或中转站须记录产品的接收与交付情况。交易所有权随时出于监督检查目的查阅相关记录与仓库收据。
- 7.15. Агуулахын баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн итгэмжлэгдсэн агуулах, терминал хариуцна.
- 7.15. 仓库收据的真实性与准确性由出具该收据的授权仓库或中转站负责。

Чанарын хяналт

质量监管

- 7.16. Худалдагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийлгэх гэрээг биржийн итгэмжлэгдсэн лабораторитой байгуулна.
- 7.16. 卖方应与交易所经授权的实验室签订对存放于经授权仓库或中转站的产品进行质量检验的协议。

Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
 铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

- 7.17. Итгэмжлэгдсэн лаборатори нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршсан бүтээгдэхүүнээс Монгол Улсын холбогдох стандартад заасан аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийнэ.
- 7.17. 经授权的实验室应根据蒙古国相关标准规定的方法，从存放在经授权仓库或中转站的产品中采集样品并进行分析。
- 7.18. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалд хүлээн авах болон агуулахаас ачилт хийх үеийн жинг үнэн зөв тооцож, баталгаажуулна.
- 7.18. 经授权的仓库或中转站应在产品入库及出库装运时，准确计量产品重量并进行确认。
- 7.19. Итгэмжлэгдсэн лаборатори нь бүтээгдэхүүний чанарын шинжилгээг хийж дууссаны дараа шинжилгээний дүгнэлтийн эх хувийг агуулах, терминалд, хуулбар хувийг Бирж болон худалдагчид хүргүүлнэ.
- 7.19. 经授权的实验室完成质量检测后，应将检测结果原件交付至仓库或中转站，副本提交至交易所及卖方。
- 7.20. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудаст дээжийн мэдээлэл, сорилт, шинжилгээг гүйцэтгэсэн стандарт, шинжилгээ хийсэн үзүүлэлт, зөвшөөрөгдөх хэмжээ, хэмжих нэгж, үр дүнг тусгасан байна.
- 7.20. 经授权实验室出具的检测结果报告应包含样品信息、试验内容、所采用的检测标准、检测指标、允许限值、计量单位及检测结果。
- 7.21. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалаас ачих үед итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг худалдан авагчид хүлээлгэн өгнө.
- 7.21. 经授权仓库或中转站在从仓库或中转站装运产品时，应将经授权实验室的检测结果交付给投标者。
- 7.22. Чанарын маргаанаас шалтгаалан агуулах, терминалаас ачилт хийгдээгүй тохиолдолд худалдан авагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэн ачилтыг түр хойшлуулж болно. Энэ тохиолдолд худалдан авагч нь Биржээс бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор давтан шинжилгээ хийлгэх хүсэлтийг Биржид гаргана. Давтан шинжилгээ хийлгэх хүсэлтэд агуулах, терминалын нэр, бүтээгдэхүүний байршил, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, холбоо барих хаяг болон шаардлагатай бусад мэдээллийг тусгаж, албан ёсны тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Давтан шинжилгээг худалдагч, худалдан авагчийн тохиролцож сонгосон Биржийн итгэмжилсэн шинжилгээний лаборатори гүйцэтгэх бөгөөд давтан шинжилгээний үр дүнгээс хамаарч төлбөрийг худалдан авагч эсхүл худалдагч хариуцна.
- 7.22. 若因质量争议导致产品未能从仓库或中转站装运，投标者可通知经授权的仓库或中转站暂缓装运。在这种情况下投标者可收到交易所发出的产品接收通知后的3个工作日内向交易所提出复检申请。复检申请中应包含仓库或中转站名称、产品位置、数量、质量指标、联系方式及其他必要信息，并加盖公章确认。复检工作由卖方与投标者共同协商选定的、交易所经授权的实验室执行。根据复检结果，决定由投标者或卖方承担相关费用。
- 7.23. Худалдан авагч нь заасан хугацаанд тогтоосон журмын дагуу давтан шинжилгээ хийлгэх
- Төмрийн хүдэр, баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
- 铁矿石及精矿交易协议标准制定与执行条例

хүсэлт гаргаагүй тохиолдолд агуулах, терминалаас ачсан бүтээгдэхүүний чанарыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

7.23. 若投标者未在规定时间内按程序申请复检，则视为投标者认可从仓库或中转站装出的产品质量。

7.24. Давтан шинжилгээний үр дүн нь бүтээгдэхүүний чанарын маргааныг шийдвэрлэх үндэслэл болно.

7.24. 复检结果将作为解决矿产商品质量争议的依据。

7.25. Давтан шинжилгээний дүн болон анхны шинжилгээний дүн нь Монгол улсын Стандарт, хэмжил зүйн газраас баталсан холбогдох стандартаар тогтоосон стандарт хазайлтын хүрээнд багтах тохиолдолд бүтээгдэхүүнийг гэрээнд заасан чанарын шаардлага хангасан гэж үзнэ.

7.25. 若复检结果与初检结果在蒙古国家标准与计量局核准标准所规定的误差范围内的话视为检验 质量符合要求。

7.26. Давтан шинжилгээний дүн болон анхны шинжилгээний дүн нь зөрүүтэй бөгөөд уг зөрүү стандарт хазайлтын хүрээнээс илүү гарсан тохиолдолд худалдагч болон худалдан авагч талуудын хооронд байгуулсан экспортын гэрээ буюу худалдах, худалдан авах гэрээгээр зохицуулна.

7.26. 若复检结果与初检结果存在差异，且该差异超出标准误差范围，则依照卖方与投标者之间签署的出口协议或买卖协议进行处理。

